

Э-Сонин

35 дахь дугаар



Мэдээний Тойм



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР
М.БОЛОРЫГ ТОМИЛОО**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНЫ
ИДЭВХИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ
2016 ОНД FTSE-ИЙН “FRONTIER
MARKET” ЗЭРЭГЛЭЛД НЭР
ДЭВШЛЭЭ**

**БЛҮМБЕРГТ МОНГОЛЫН ХУВЬЦААТ
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ БАЙРШИЖ
ЭХЭЛЛЭЭ**




**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД РЕПО
АРИЛЖААГ НЭВТРҮҮЛНЭ**

**НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ СЭЛЭНГЭ АЙМАГТ
БОЛНО**



**“УИД” ХК-ИЙН ЖИЖИГ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМНӨӨС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАЛАА**

**“MN STOCKS” ANDROID
ҮЙЛДЛИЙН СИСТЕМ ДЭЭР
АЖИЛЛАДАГ БОЛОО**



ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- Гадаадын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн 8 дугаар сард 469,642,736 төгрөгт хүрч оны мөн үетэй харьцуулахад 5.3 дахин өссөн байна.
- Их Британийн “FTSE Group”-ийн Засаглал, бодлого хариуцсан захирал Кристофер Вүүдсээс 2015 оны 9-р сарын 11-ний өдөр МХБ нь FTSE зэрэглэлд орлоо.
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тайлан болон мэдээллүүд “Bloomberg Terminal”-д байршиж эхлээд байна.
- ЗГҮЦ-ны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засагт богино хугацаат зээлийн хүүгийн хэмжээг бодитоор тогтоох, хөрөнгө оруулагчдад худалдан авсан үнэт цаасыг хугацаанаас нь өмнө үр ашигтай.
- “Улсын Их Дэлгүүр” хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчдээс ирсэн санал гомдол нь хэр үндэслэлтэй вэ гэдгийг тогтоохоор СЗХ шүүхэд хандсан байна.
- “MN Stocks” аппликейшныг Android төрлийн үйлдлийн системтэй утсан дахь “Play Store” сангаас суулган ханшийн мэдээллээ харах боломжтой боллоо.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 9 дүгээр сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 11313747 -126 дугаараас авна уу.



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР М.БОЛОРЫГ ТОМИЛОО


“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар Д.Ангарыг үүрэгт ажлаас чөлөөлж, М.Болорыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томиллоо.

Мөнхсайханы Болор нь ХБНГУ-ын Берлин хотын Эдийн засгийн сургууль болон АНУ-ын Техас муж дахь Райсын их сургуульд мэргэжил дээшлүүлж, улмаар Люксембургийн их сургуулийн Санхүүгийн сургуульд Банк, санхүүгийн чиглэлээр Шинжлэх ухааны магистрийн зэрэг хамгаалсан. Тэрээр ажлын гараагаа Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газарт эдийн засагчаар эхэлсэн. Тус байгууллагад арав гаруй жил ажиллах хугацаандаа арилжааны банкуудын баланс, зээлийн тайлан, аймгуудын тайлан болон судалгааны бюллетень зэргийн ерөнхий загварчлалыг боловсруулж улс орон даяар хэрэглээнд нэвтрүүлжээ. Мөн Монгол улсын эдийн засгийн макро загвар, салбар хоорондын бүтэц зэрэг сэдвээр судалгааны ажил хэвлүүлсэн. 2013 онд судалгаа шинжилгээний “Элүдэй” ХХК-г үүсгэн байгуулж бизнес консалтингийн салбарт ажилласан туршлагатай юм.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНЫ ИДЭВХИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Гадаадын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн 8 дугаар сард 469,642,736 төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 дахин өссөн байна. Мөн дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн 36,685,852,328 төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.3 дахин өсөж хөрөнгө оруулагчдийн идэвх өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байна.

2015 оны найман сарын байдлаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин өсөж 6,025,625,952 төгрөгт хүрчээ. Мөн дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.3 дахин өсөж 359,184,691,472 төгрөгт хүрч гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2016 ОНД FTSE-ИЙН “FRONTIER MARKET” ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШЛЭЭ



Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн “FTSE Group”-ийн Засаглал, бодлого хариуцсан захирал Кристофер Вүүдсээс 2015 оны 9-р сарын 11-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангарт албан бичиг ирүүлээ.

Уг албан бичигт FTSE группийн Засаглалын зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын хурлаар Монголын хөрөнгийн зах зээлийг “Frontier” хөгжиж буй зэрэглэлийн “Ажиглалтын жагсаалт”-д үлдээж, 2016 оны 9 дүгээр сард болох дараагийн ээлжит хурал буюу 2016 оны үнэлгээгээр зэрэглэл дэвшүүлж “Frontier market” статус олгох боломжийн талаар дурдсан байна.

Монголын хөрөнгийн зах зээл цаашид зэрэглэл дэвшихийн тулд үнэт цаасны Кастодианы үйлчилгээг нэвтрүүлэх, үнэт цаасны төлбөр тооцоог боловсронгуй болгох, хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зээлийн арилжааг /Short sell, Stock Lending/ нэвтрүүлэх, биржийн бус арилжаа /Off-exchange transaction/, үүсмэл үнэт цаасыг зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийх шаардлагтай байна.

Жич: Их Британийн нийслэл Лондон хотноо байрладаг “FTSE групп” нь олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч компани бөгөөд 80 гаруй улсын хөрөнгийн зах зээлийн 250 мянга гаруй индексийг арилжааны явцад шууд болон арилжааны эцэст тооцоолж гарган, зах зээлд мэдээлдэг бөгөөд хөрөнгийн зах зээл хөгжсөн 168 орноос 76 орон тус байгууллагаар зэрэглэлээ тогтоолгосон байдаг юм.

БЛУМБЕРГТ МОНГОЛЫН ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ БАЙРШИЖ ЭХЭЛЛЭЭ




Монголын хөрөнгийн биржээс Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг “Bloomberg Terminal”-аар дамжуулж олон улсад түгээх, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийг идэвхжүүлэх ажлыг хийж байгаа билээ.

Тус ажлын хүрээнд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн мэдээллүүд “Bloomberg Terminal”-д байршиж эхлээд байна.

Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээлэл олон улсад илүү нээлттэй, ил тод, түргэн шуурхай түгэх боломж нээгдэж, гадаадын хөрөнгө оруулагчид нэмэгдэх таатай алхам боллоо.

“Bloomberg Terminal” дахь “АПУ” ХК-ийн мэдээлэл:



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД РЕПО АРИЛЖААГ НЭВТРҮҮЛНЭ

Монголын хөрөнгийн биржээр өнгөрсөн оны 11 сараас эхлэн 12, 28, 52 долоо хоногийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 400 гаруй тэрбум төгрөгийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа хийгдсэн байна.

Монголын хөрөнгийн бирж нь ЗГҮЦ-ны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засагт богино хугацаат зээлийн хүүгийн хэмжээг бодитоор тогтоох, хөрөнгө оруулагчдад худалдан авсан үнэт цаасыг хугацаанаас нь өмнө үр ашигтай нөхцөлтэйгээр эдийн засгийн эргэлтэнд оруулах шинэ боломжийг бий болгох үүднээс “буцаан худалдан авах нөхцөлтэй репо арилжааг” зах зээлд энэ оны 10 сард нэвтрүүлэхээр ажиллаж байна.

НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ СЭЛЭНГЭ АЙМАГТ БОЛНО

Монголын Хөрөнгийн бирж Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” арга хэмжээг Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулахаар боллоо. Нээлттэй өдөрлөгийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжид үнэт цаасны зах зээлийн нэг цэгийн үйлчилгээг үзүүлнэ.

Үүнд:

- Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох, Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн талаарх мэдээлэл
- Хувьцаа, бонд гаргах замаар хөрөнгө оруулалт босгох талаарх мэдээлэл, зөвлөмж
- Засгийн газрын үнэт цаасны мэдээлэл, танилцуулга
- Хувьцаат компанийн ногдол ашгийн талаарх мэдээлэл
- Хөрөнгө оруулалтын зөвлөгөө
- Брокерийн арилжааны данс нээх үйлчилгээ
- Данс шүүх үйлчилгээ
- Үнэт цаастай холбоотой иргэдийн санал хүсэлт
- 2015-2016 онд Монголын Хөрөнгийн биржээр дамжин хувьчлагдах төрийн өмчит компаниудын хувьцааны арилжаанд хэрхэн оролцох талаар мэдээлэл

Энэ оны эхний хагаст нээлттэй өдөрлөг арга хэмжээг Улаанбаатар хот, Орхон аймагт зохион байгуулсан юм. Өдөрлөгийн үеэр иргэдийн дунд хүлээлт үүсгээд байгаа "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 1,072 хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх асуудлаарх мэдээлэл өгч, ягаан цэнхэр тасалбартай холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах нэг цэгийн үйлчилгээг үзүүлж, иргэд талархалтайгаар хүлээн авсан юм. Цаашид уг арга хэмжээ үргэлжлүүлэн бусад аймгуудад зохион байгуулахаар боллоо.

“УИД” ХК-ИЙН ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМНӨӨС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАЛАА

“УИД” хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хохироож байгаа талаар жижиг хувьцаа эзэмшигчид гомдоллоод удаж байна. Тэдний гомдлын дагуу Санхүүгийн зохицуулах хороо шалгалт хийгээд шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн дарга Н.Батгэрэлээс тодрууллаа.

-Улсын Их дэлгүүрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдлын дагуу хийсэн шалгалтын талаар тодруулахгүй юү?

“Улсын Их Дэлгүүр” хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигчдээс удаа дараа гомдол ирж байсан. Тэдний гаргасан гомдол хэр үндэслэлтэй вэ гэдгийг тогтоохоор газар дээрх шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос хоёр ч удаа хийгээд байна. Тодруулбал, Хорооноос томилогдсон ажлын хэсэг 2015 оны хоёрдугаар сар, дөрөвдүгээр сард шалгалт явуулсан. Ингэхдээ “УИД” ХК-ийн холбогдох этгээдүүд болох “Номин Холдинг”, “Номин тав”, Номин реалтор” компаниудын хооронд хийгдсэн гүйлгээ, гэрээ хэлцэл бүрийг санхүүгийн баримт, үндсэн гэрээнүүдэд тулгуурлан явуулсан.

-Гол нь шалгалтаар ямар дүгнэлт гарсан бэ. Үнэхээр жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хохироосон зөрчил дутагдалтай байсан үү?

“Номин Холдинг” группын гишүүн компаниудын хооронд хийсэн гэрээ, хэлцлүүд, эдгээрийн үндсэн төлбөр тооцоо нь зарим талаар сонирхолын зөрчилтэй, жижиг хувьцаа эзэмшигчдийн



хувьд ашиггүй, дүр үзүүлсэн болохгүйгээ халхавчилсан гэрээ байх магадлалтай гэж шалгалтын ажлын хэсэг дүгнэсэн. Тухайлбал, 2008 оноос хойш хийсэн түрээсийн болон зээлийн нийт 13 гэрээг хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл мөн эсэх нь эргэлзээтэй байгаа. Эдгээр гэрээг хүчин төгөлдөр үү гэдгийг тогтоолгохоор жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг өмнөөс Санхүүгийн зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэх гаргаад байна.

-Шүүхэд нэхэмжлэл гаргах бол жижиг хувьцаа эзэмшигчид гаргах ёстой юм биш үү. Яагаад Санхүүгийн зохицуулах хороо нэхэмжлэл гаргаж байгаа юм бэ?

-Жижиг хувьцаа эзэмшигчид шүүхэд

нэхэмжлэл гаргахад төлөх тэмдэгтийн хураамж өндөр гарна. Нэгэнт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг нь бидэнд бий учраас Санхүүгийн зохицуулах хороо тэдний өмнөөс нэхэмжлэл гаргаж байгаа юм. Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд зааснаар төрийн байгууллагын гаргаж буй нэхэмжлэлд хураамж төлдөггүй.

-Санхүүгийн зохицуулах хороо жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлж нэхэмжлэл гаргаж байгаа нь ямар нэг хууль зөрчсөн үйлдэл биш гэсэн үг үү?

-Хууль зөрчсөн үйлдэл биш. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан нь хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироосон, хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Хороо хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно” гэж заасан. Мөн тус хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.16-д “Шаардлагатай тохиолдолд үнэт цаас эзэмшигч /хувьцаа эзэмшигч/ -ийн нэрийн өмнөөс тэдгээрийн эрх ашгийн төлөө итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалтуудыг хууль зүйн үндэслэл болгон шүүхэд нэхэмжлэл гаргаж байна гэсэн үг. “УИД” ХК-ийн 54.415 жижиг хувьцаа эзэмшигчийн өмнөөс гаргаж буй нэхэмжлэл юм.

-“УИД” хувьцаат компани хэр олон хувьцаатай юм бэ?

-100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36,807,850 ширхэг энгийн хувьцаатай. Үүнээс томоохон хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 68.4 хувийг эзэмшдэг. Үлдсэн хувийг 45,415 жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг.

-Өмнө нь хувьцаа эзэмшигчиддээ хуулийн дагуу хүртэх ёстой ногдол ашгийг нь тарааж чадаж байсан болов уу?

-“Улсын их дэлгүүр” хувьцаат компани нь 2001 онд 30 мөнгө, 2007 онд 3 төгрөгийн ногдол ашиг хуваарилаж байсан. Харин бусад жилүүдэд алдагдалтай ажилласан гэх шалтгаанаар ногдол ашиг хуваарилаагүй байдаг юм. Бас нэг сонирхолтой зүйл нь энэ хувьцаат компани ердөө хоёрхон ажилтантай. Гүйцэтгэх захирал С.Сайнбаяр нь “Номин Холдинг” ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирлаар, нягтлан бодогч Б.Ээжиймаа нь мөн “Номин Холдинг” ХХК -ийн ахлах нягтлан бодогчоор ажилладаг байгаа юм. “УИД” ХК-ийн гүйцэтгэх захирал, нягтлан нь давхар “Номин Холдинг” ХХК-ийн захирал, нягтлан хийдэг гэсэн үг.

-“Улсын Их дэлгүүр” хувьцаат компанийн үндсэн үйл ажиллагаа нь юу юм бэ?

-Өөрийн хөрөнгө болох худалдааны зориулалттай долоон давхар байшин / Улсын их дэлгүүр/-ийг 2002 оноос хойш “Номин Холдинг” ХХК болон түүний охин компаниуд болох “Номин реалтор”, “Номин тав” ХХК-иудад түрээслүүлдэг үндсэн үйл ажиллагаатай компани.


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо - <http://frc.mn/news/1230>

“MN STOCKS” ANDROID ҮЙЛДЛИЙН СИСТЕМ ДЭЭР АЖИЛЛАДАГ БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан аппликейшны тусламжтайгаар 2014 оны 10 дугаар сараас эхлэн хүргэж байгаа билээ.

Тус аппликейшн нь Apple компанийн бүтээгдэхүүн болох IOS үйлдлийн систем дээр ажилладаг байсан ба хэрэглэгчдээс олноор ирсэн санал хүсэлтийн дагуу Android төрлийн үйлдлийн системд нийцэх хувилбарыг амжилттай хөгжүүллээ.

Ингэснээр “MN Stocks” аппликейшныг Samsung, HTC, Google Nexus, LG, Motorola, Sony зэрэг бүх Android төрлийн үйлдлийн системтэй утсан дахь “Play Store” сангаас суулган ханшийн мэдээллийг өөрийн сонирхсон үнэт цаасуудаар багц үүсгэн ашиглах боломжтой юм.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 9 дүгээр сарын 21-нээс 9 дүгээр сарын 25-ны хооронд явагдаж дууслаа.

Энэ удаагийн сургалтанд хамрагдсан суралцагчид харилцах дансаа нээлгэн бодит арилжаанд оролцсоноороо онцлог боллоо. Тус сургалтад хамрагдсанаар та хөрөнгийн зах зээлийн ерөнхий ойлголт, үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын тухай, арилжаанд хэрхэн оролцох, оновчтой багц бүрдүүлэлт, арилжааны сэтгэл зүй г.м цаашид гүнзгийрүүлэн суралцахад суурь цогц мэдлэгтэй болох юм.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



2015 оны 09 дүгээр сар

Арилжааны товч мэдээ	
Арилжигдсан ширхэг	2 401 204
Нийт үнийн дүн /төг/	48 496 309 428,10
Хэлцлийн тоо	458
Арилжигдсан үнэт цаасны тоо	79
Зах зээлийн үнэлгээ /төг/	1 289 804 963 251
ТОП-20 индекс	
Хаалт	13 129,04
Өөрчлөлт /%/	1,85
MSE ALL индекс	
Хаалт	954,21
Өөрчлөлт /%/	0,34



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:						
Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:		
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнийн дүн
1	RMC	РЕМИКОН	1 506 296	1	BDS	БИ ДИ СЕК
2	MRX	МЕРЕКС	156 960	2	APU	АПУ
3	BDS	БИ ДИ СЕК	87 286	3	RMC	РЕМИКОН
4	APU	АПУ	34 459	4	HZB	ГАН ХЭРЛЭН
5	HZB	ГАН ХЭРЛЭН	14 542	5	MMX	МАХИМПЕКС

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:						
№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт		
				%		
1	RMC	РЕМИКОН	1 506 296	1	BDS	БИ ДИ СЕК
2	MRX	МЕРЕКС	156 960	2	APU	АПУ
3	BDS	БИ ДИ СЕК	87 286	3	RMC	РЕМИКОН
4	APU	АПУ	34 459	4	HZB	ГАН ХЭРЛЭН
5	HZB	ГАН ХЭРЛЭН	14 542	5	MMX	МАХИМПЕКС

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:						
№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт		
				%		
1	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	5 500,00			30,33
2	UNS	УЛААНСАН	1 350,00			22,73
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	3 700,00			19,12
4	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	529,70			19,03
5	TUS	ТҮШИГ УУЛ	499,00			18,81

Хамгийн их бууралттай үнэт цаас:						
№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт		
				%		
1	ME	МАТЕРИАЛИМПЕКС	11 400			-21,38
2	SHG	ШАРЫН ГОЛ	4 238			-15,24
3	SHV	ШИВЭЭ ОВОО	4 200			-15,15
4	NE	НОЁТ ХАЙРХАН	1 275			-15,00
5	SUL	ГАЗАР СҮЛЖМЭЛ	40 880			-14,98

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/						
№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-12-326	100 000	9 687 900 000	96 879	12	14,000
2	ЗГХБ-Б-28-327	100 000	9 302 100 000	93 021	28	13,971
3	ЗГХБ-Б-52-328	100 000	8 735 700 000	87 357	52	14,512
4	ЗГХБ-Б-12-329	100 000	9 692 700 000	96 927	12	13,776
5	ЗГХБ-Б-28-330	100 000	9 303 200 000	93 032	28	13,948

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/						
№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлийн ханш
1	ZGEB-BL-04/11/15-A0047-0	11 782	1 150 747 940	97 670	97 670	97 670
2	ZGEB-BL-13/09/16-A0055-0	2	175 000	87 500	87 500	87 500